



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/468

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.17 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.8, 25.9.1 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.7, 2.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох гадаадын 6 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг давтан олгох гадаадын 2 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /П.Эрхэмбаяр/-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222216

Эрүүл мэндийн сайдын 2022  
оны ..... дүгээр сарын 16-өдрийн  
А.Н.Б.З дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АНХ УДАА ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1	Кертес Петер Жонн	Канад	Улсын Нэгдүгээр төв эмнэлэг	-	ГЭ0002629	Нүд судлал	Эмчлэх	/2022.09.15- 2022.10.08/ 24 хоног
2	Гупта Прия	Канад	Улсын Нэгдүгээр төв эмнэлэг	-	ГЭ0002630	Нүд судлал	Эмчлэх	/2022.09.15- 2022.10.08/ 24 хоног
3	Мортел Алан Иоган	Ирланд	Эх Хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төв	-	ГЭ0002631	Мэс засал судлал	Эмчлэх	/2022.09.24- 2022.10.01/ 8 хоног
4	Монтаго Тэрэнс Лауренс	Ирланд	Эх Хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төв	-	ГЭ0002632	Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ	Эмчлэх	/2022.09.24- 2022.10.01/ 8 хоног
5	Фрайл Вивони Мэйри	Ирланд	Эх Хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төв	-	ГС0000321	Сувилахуйн судлал	Сувилахуй	/2022.09.24- 2022.10.01/ 8 хоног
6	Кассандра Эрин	Канад	Улсын Нэгдүгээр төв эмнэлэг	-	ГС0000320	Сувилахуйн судлал	Сувилахуй	/2022.09.15- 2022.10.08/ 24 хоног

Эрүүл мэндийн сайдын 2022  
 оны 09 дүгээр сарын 16 өдрийн  
 А/Н68 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ДАВТАН ОЛГОХ  
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1	Ахмад Шах Ашраф	Канад	Хавдар судлалын үндэсний төв	-	ГЭ0002627	Цээжний мэс засал судлал	Эмчлэх	/2022.09.26- 2022.09.30/ 5 хоног
2	Мин Сан Ил	БНСУ	Улсын Нэгдүгээр төв эмнэлэг	-	ГЭ0002628	Мэс засал судлал	Эмчлэх	/2022.09.20- 2022.09.26/ 7 хоног